






ИНВЕСКОР ББСБ ХК
2020 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН
ТАЙЛАН

ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2020 оны 1 дүгээр улирлын үзүүлэлтүүдийг 2019 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад харилцагчдын тоо **250%**, зээлийн багц **5%**, зээл олголтын дүн **7%**-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

	2018.IV	2019.IV	2020.I	ӨСӨЛТ
Харилцагчийн тоо	2,230	10,690	37,364	↑ 250%
Зээлийн багцын дүн /сая MNT/	34,868	62,308	65,198	↑ 5%
Зээл олголтын дүн /сая MNT/	84,022	166,880	179,338	↑ 7%
Чанаргүй зээл /хувиар/	4.8%	2.6%	2.6%	

2020 оны 1 дүгээр улирлын санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийн байдал:



2020 оны 1 дүгээр улирлын санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг өмнөх оны эцэстэй харьцуулахад өөрийн хөрөнгө **16%**, нийт хөрөнгийн дүн **9%**, нийт орлого **7%**-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.



ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН



✓ Rocket цахим зээл, хэтэвч аппликейшн:

2020 оны 1-р улиралд "Инвескор" Санхүүгийн групп нь өөрсдийн шинэ үйлчилгээ болох "Rocket" аппликейшнийг зах зээлд танилцууллаа.

Покет аппликейшн нь "Инвескор" Санхүүгийн группын охин компани болох "Инвескор Хэтэвч ББСБ" ХХК-ийн гаргаж буй хиймэл оюун ухаанд суурилсан Финтек бүтээгдэхүүн юм.

Хэрэглэгчдэд барьцаагүй, урамшуулалт хугацаандаа хүүгүй, 20,000₮-өөс 10,000,000₮ хүртэлх зээлийг санал болгох энэхүү аппликейшн нь цахим зээл, төлбөр тооцоо, гүйлгээний цогц хэтэвч юм.

Покет аппликейшны онцлог давуу тал нь батлан даалттай зээл болон зэрэглэлийн систем ба олон боломжит бонус оноонуудыг тогтмол цуглуулснаар зээлийн хэмжээгээ нэмэгдүүлж, шимтгэлээ бууруулах урамшууллын систем бүхий цогц аппликейшн юм.

✓ Шуурхай зээл

Автомашин, Орон сууц барьцаалсан 50,0 сая төгрөг хүртэлх дүнтэй шуурхай зээлийг хамгийн боломжит нөхцөлөөр санал болгож, зээлийг 1 цагийн дотор шийднэ. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нийтдээ 711 сая төгрөгийн шуурхай зээл олгосон байна.

✓ Шинэ салбарууд

Байгууллага үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгын хүрээнд Энхтайван, Хан-Уул, Нарантуул, Шангри-Ла, Баянзүрх, Бизнес Төв салбаруудыг шинээр байгуулан, Дүнжингарав салбарт өргөтгөл хийлээ.

ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Covid-19 вирустэй холбоотой Улсын Онц байдлын үеэр авсан арга хэмжээ:



Бизнесийн зээлийн шимтгэл 0% болгосон ба 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 1.4 тэрбумын бизнесийн зээл олгосон.



Covid-19 харилцагч нарт зээлийн өөрчлөлт оруулсан- 2.8 тэрбумын төгрөгийн зээлийн багцанд 200 гаруй харилцагчдын зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж байна.



Бизнесийн зориулалтаар авсан зээлийн төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулах эсвэл зээлийн гэрээний хугацааг сунгахад харилцагчаас ямар ч шимтгэл авахгүй.



Бизнесийн үйл ажиллагаанд нь хүндрэл учирч, зээлийн эргэн төлөлттэй холбоотой бэрхшээл үүссэн бол зээлдэгч хариуцсан салбартаа хандан "Зээлийн нөхцөл өөрчлөх" хүсэлтийг шийдвэрлэж байна.



Рокет аппликэйшн ашигладаг харилцагчдын хувьд дээрх зохицуулалтын хугацаанд зохих шимтгэлийг төлж, зээлийн хугацааг сунгах боломж нээлттэйгээр ажиллаж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Хүүгүй бизнесийн зээлийн тусламж

Дэлхий дахинд тархаад байгаа "Covid-19" короновирус нь хурдацтай тархаж байгаа энэ үед дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор "Монгол Маск Эрдэнэт" ХХК-д 30 сая төгрөгийн хүүгүй зээлийг олголоо.



Улсын Онцгой Комисс-д хандив өгөв

Мөн "Covid-19"-тэй холбогдуулан Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагын Холбооноос зохион байгуулсан "Улсын Онцгой Комисс"-т 100 сая төгрөг хандивлахад оролцлоо.

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН		/мянган төгрөг/		
	2020 Q1	2019 Q4	2018Q4	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,651,808	5,146,145	2,320,122	
Богино хугацаат хөрөнгө оруулалт	7,153,617	3,599,750	-	
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	65,198,170	62,307,875	34,868,286	
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	674,589	1,055,576	417,534	
Бусад хөрөнгө	5,582,227	2,309,789	811,254	
Үндсэн ба биет бус хөрөнгө	7,204,250	7,483,027	605,899	
Нийт хөрөнгийн дүн	89,464,660	81,902,162	39,023,095	
ӨР ТӨЛБӨР				
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	21,841,837	19,933,800	10,374,109	
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	9,574,323	14,515,976	13,867,446	
Бусад санхүүгийн өр төлбөр	11,120,719	7,063,692	890,461	
Нийт өр төлбөрийн дүн	42,536,879	41,513,468	25,132,016	
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ				
Хувьцаат капитал	18,782,237	13,839,902	6,096,873	
Бусад өмч	15,377,738	15,377,738	-	
Хуримтлагдсан ашиг /(алдагдал)	12,767,806	8,728,719	7,794,206	
Нийт өөрийн хөрөнгө	46,927,781	40,388,694	13,891,079	
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	89,464,660	81,902,162	39,023,095	

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН		/мянган төгрөг/		
	2020 Q1	2019 Q4	2018 Q4	
Хүү болон түүнтэй адилтгах орлого	5,546,463	19,362,985	10,794,001	
Хүү болон түүнтэй адилтгах зардал	(457,000)	(4,192,760)	(2,572,561)	
Хүүгийн цэвэр орлого	5,089,463	15,170,225	8,221,440	
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	617,371	2,600,157	324,140	
Гадаад валютын арилжаа болон ханшийн тэгшитгэлийн орлого/ зардал	211,808	159,154	77,927	
Хүүгийн бус орлого	5,918,641	17,929,536	8,623,507	
Ажиллагсадтай холбогдолтой зардал	(689,719)	(3,000,568)	(902,020)	
Үйл ажиллагааны бусад зардал	(1,220,857)	(3,664,400)	(663,608)	
Зээлийн үнэ цэнийн бууралтын өмнөх ашиг, алдагдал	4,008,064	11,264,568	7,057,879	
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	(769,824)	(56,963)	(880,264)	
Татварын өмнөх ашиг	3,238,240	11,207,605	6,177,615	
Орлогын албан татвар	(308,606)	(2,548,913)	(1,123,938)	
Тайлант үеийн цэвэр ашиг	2,929,634	8,658,692	5,053,677	

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2020 оны 4 сарын 9-нд “Инвескор ББСБ” ХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурал” цахим хэлбэрээр зохион байгуулагдсанаараа онцлогтой юм.

Тус хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар хуралдахад “Инвескор Эй Ай Лаб” ХХК дуу хоолойгоор таних хиймэл оюун ухаанд суурилсан системийг амжилттай хөгжүүлсэн ба санал хураах, асуулт хариулт, ирц бүртгэх гэсэн цогц хэсгээс бүрдсэн системийг нэвтрүүлсэн Монгол улсад анхны байгууллага боллоо.

Хувьцаа эзэмшигчдийн хурал нь **99.5** хувийн ирцтэй амжилттай зохион байгуулагдаж дараах асуудлуудыг 99.75 хувиар тус тус баталлаа.

- ✓ Компанийн дүрэмт нэмэлт өөрчлөв.
- ✓ 2020 оны ТУЗ-ийн төсөв батлав.
- ✓ Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан батлав.

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Ханшийн өсөлт

49%

Нийт арилжаалагдсан ширхэг

1'588'710

Нийт арилжаалагдсан үнийн дүн

₮2'022'692'581

Өдрийн дундаж арилжааны дүн

₮10.0 сая

ХАНШИЙН ӨӨРЧЛӨЛТ 2020 ОНЫ 1 УЛИРЛЫН БАЙДЛААР

